

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 46.000.01

Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар. Ерөнхий шаардлага	MNS 6466 : 2022
Railway wagon's technical inspection and overhaul service. General requirements	MNS 6466 : 2016

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2022 оны оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь Монгол Улсын төмөр замын тээвэрт ашиглагдах вагонд хийгдэх техникийн үзлэг, үйлчилгээ, засварын төрөл, засвар хоорондын үечлэлийн хугацаа, үечлэл ба гүйлтийн нормыг тогтооно.

Өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан вагоны эзэмшил, өмчлөлтэй бүх иргэн, аж ахуйн нэгж нь энэхүү стандартаар тогтоосон ашиглалтын нормт хугацаа, засвар хоорондын үечлэлийн хугацаа, гүйлтийн нормыг баримтлан түүний бүрэн бүтэн, найдвартай ажиллагааг хангана.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, зөвлөмжийн баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандарт, зөвлөмжийн хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ:

- 2.1. MNS 6143:2010 “1520 мм-ийн царигтай төмөр замын ачааны вагоны хоёр голт тэргэнцэр. Техникийн ерөнхий шаардлага”;
- 2.2. MNS 6276: 2011 “Төмөр замын ачааны вагон.Техникийн ерөнхий шаардлага”;
- 2.3. MNS 6312:2012 “Төмөр замын зорчигчийн вагон. Техникийн ерөнхий шаардлага”;
- 2.4. MNS 6387-3:2013 “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний нэр томьёо, тодорхойлолт”;
- 2.5. MNS 3084-2013 “Төмөр замд ачилт, буулгалт ба сэлгээний ажлын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангахад тавих ерөнхий шаардлага” ;
- 2.6. MNS 5833:2014 “Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөхбүрэлдэхүүний овор хэмжээ”;
- 2.7. MNS 6500:2014 “Төмөр замын зорчигчийн вагоны техникийн нөөцийн үнэлгээ.Ерөнхийшаардлага”;
- 2.8. MNS 6431:2014 “Вагоны эд ангийг үл эвдэх сорилын аргаар шалгах. Ерөнхийшаардлага”;
- 2.9. MNS EN 12080: 2013 “Төмөр зам. Өнхрөх холиховчтой хайрцган гүүшин.

- Техникийн ерөнхий шаардлага”;
- 2.10. MNS EN15380-1,2,3:2016 Төмөр замын хэрэглээ. Вагон түүний эд ангид тэмдэг, тэмдэглэгээ, бичлэг хийх шаардлага;
 - 2.11. MNS EN 15877-1,2:2016, Төмөр замын ашиглалт – Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн дээр тэмдэг, тэмдэглэгээ тавих;
 - 2.12. MNS EN 12561-1,2,3,4,5: 2016 Төмөр замын хэрэглээ : Аюултай ачаа тээвэрлэх зориулалттай цистерн вагонд зориулсан техникийн шаардлага, юүлэх төхөөрөмж;
 - 2.13. MNS EN 15085-1,2,3,4,5:2007 Төмөр замын хэрэглээ–Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн болон түүний эд ангиудыг гагнах нь-Хэсэг 1: Ерөнхий зүйл, шаардлагууд;
 - 2.14. MNS EN 15877-1.2: 2016 Төмөр замын хэрэглээ – Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн болон түүний эд ангиудыг гагнах нь – Хэсэг 1: Ачааны вагон;
 - 2.15. MNS EN 13260 : 2016: Төмөр замын хэрэглээ- Хос дугуй ба тэргэнцэр-Хос дугуй-Бүтээгдэхүүний шаардлагууд;
 - 2.16. MNS EN 13715:2016 Төмөр замын хэрэглээ – Хос дугуй ба тэргэнцэр – Хос дугуй–Өнхрөх гадаргын хэлбэр;
 - 2.17. MNS EN 15687 : 2016 Төмөр замын хэрэглээ 225кН-250кН ба түүнээс дээш голын статик ачаалалтай ачааны вагоны ажлын /гүйлтийн/ үзүүлэлтийг зөвшөөрөх туршилт;
 - 2.18. MNS EN 15427+A1:2016 Төмөр замын хэрэглээ- Дугуй, зам төмөр харилцан үйлчлэлийн үүсэх үрэлтэд арга хэмжээ авах нь- Дэлний тосолгоо;
 - 2.19. MNS EN 15437-1 : 2016 Төмөр замын ашиглалт – Гүүшин хянах – харилцан үйлчлэлийн зааг болон хийцийн шаардлагууд–хэсэг1: Зам төмрийн гадаргуу болон хөдлөх бүрэлдэхүүний гүүшингийн төхөөрөмж;
 - 2.20. MNS EN-12081: 2016 Төмөр замын хэрэглээ. Гүүшин-Тосолгооны материал;
 - 2.21. MNS EN-12082: 2016 Төмөр замын хэрэглээ. Холхивчны хайрцаг-Ашиглалтын сорил;
 - 2.22. MNS EN 13913:2016, Төмөр замын хэрэглээ- Резинэн дүүжингийн иж бүрдэл Уян полимер дээр суурилсан механик эд ангиуд;

3. Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томъёог MNS 6387-3:2013 “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний нэр томъёо, тодорхойлолт” стандартад зааснаар болон доор тодорхойлсноор ойлгоно.

Бүрэн бүтэн байдал - техник ашиглалтын нормоор тогтоосон шаардлагад нийцсэн төлөв;

Аюулгүй ажиллагаа - вагон нь тодорхой хугацаа буюу гүйлтийн туршид өөрийн шинж чанар, ажиллах чадвараа хадгалсан тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа;

Оношилгоо - вагон түүний эд ангийг задаргаатай буюу задаргаагүй байдалд дотоод болон гадаад шинж чанарыг техникийн тоон үзүүлэлтээр тодорхойлон цаашид ашиглах нөөцийг тогтоох, үнэлэх үйл ажиллагаа;

Ашиглалтын үеийн гэмтэл - вагоны ашиглалтын үед нэг буюу хэд хэдэн үзүүлэлт

болон хэвийн дэглэм өөрчлөгдсөнөөс үүсэх эвдрэл;

Технологи - хөдөлмөрийн хэмжээ, хэлбэр, төрөл, байдал, шинж чанарыг өөрчилж бэлэн бүтээгдэхүүн гаргах зорилго бүхий тодорхой үйл ажиллагааны дараалал;

Найдвартай ажиллагаа - вагон угсрах, ашиглах, засварлах, чадварыг ханган, тогтоосон нормын дагуух сааталгүй ажиллагаа;

Ашиглалтын хугацаа - вагон үйлдвэрлэгдсэнээс хойшхи үйлдвэрлэгчийн тогтоосон нормт хугацаа болон тээвэрлэх ачааны онцлог, техникийн байдлыг үндэслэн тогтоосон нормт хугацаа;

Үйлдвэрлэгчийн тогтоосон норм - үйлдвэрлэгчийн техникийн бичиг баримтанд заасан ашиглалтын хугацаа (жил, км-ээр, мото-цаг гэх мэт);

Дахин ашиглах хугацаа - тогтоосон ашиглалтын нормт хугацаа дууссан вагонд техникийн оношилгоо хийж, вагоны үндсэн хэсгүүдийн ашиглалтын нөөцийг тодорхойлж, сэргээх их засвар хийсний дараах ашиглах хугацаа.

Сэргээх их засвараар шинэчлэн тоногдсон болон осолд орсон вагоныг засварлаж, нөөцийг дахин тогтоож болно. Ингэхдээ эрх бүхий байгууллагаар техникийн оношилгоо хийлгэж, нөөцийн үнэлгээ, баталгааг гаргуулсан байна;

Техник үйлчилгээний газар - вагонд үүсч болох гэмтлээс урьдчилан сэргийлэх техникийн үзлэг, үйлчилгээг хийхэд зориулагдсан нэгж;

Вагон засварын газар /цаашид “Депо” гэж нэрлэх/ - төмөр замын вагон, түүний зангилаа, эд ангийн засварыг гүйцэтгэх аж ахуйн нэгж;

Засварын үечлэл - засварын үечлэл гэж вагоныг үйлдвэрлэсэнээс хойш дунд болон их засвараар засварлах, засвар хоорондын төлөвлөгөөт хугацаа болон гүйлтийн нормыг хэлнэ;

Засварлагдах нөхцөл - эд ангийн элэгдэл, гэмтлээс урьдчилан сэргийлэх техникийн үзлэг үйлчилгээ болон гарсан гэмтэл, эвдэрлийн шалтгааныг тогтоож, засвар хийх технологит үйл ажиллагаа;

Төлөвлөгөөт засвар - хугацаа болон гүйлтийн үечлэлээр тодорхойлогдсон засвар;

Техникийн үзлэг, үйлчилгээ - эд анги, зангилаа хэсэг нь батлагдсан хэсэглэлийн хэмжээнд буюу тогтоосон хугацаанд ажиллах чадвартай эсэхийг баталгаажуулсан цогц үзлэг үйлчилгээ;

Техникийн үзлэг, үйлчилгээ-1 /цаашид “ТҮ-1” гэх/ - техникийн өртөөнд хийгдэх вагоны эд анги, зангилаа хэсгийн элэгдэл, гэмтэл гарах явдлаас урьдчилан сэргийлэх ба гэмтэлтэй тохиодолд засварын хэмжээг тогтоож үзлэг, зарим эд ангийн тохиргоог, тосолгоо хийх цогц үзлэг, үйлчилгээ;

(Үүнд галт тэргийг хүлээн авах, үдэн гаргах үеийн явуут дунд нь вагоны техникийн байдалд тавих хяналтыг хамруулна.)

Техникийн үзлэг үйлчилгээ-2 /цаашид “ТҮ-2” гэх/ - ачаа, зорчигчийн вагоныг зуны болон өвлийн тээвэрлэлтэнд бэлтгэн засварын бааз бүхий газарт техникийн

актаар баримтжуулан, гүйцэтгэх цогц үзлэг, үйлчилгээ;

Урсгал засвар /цаашид “УЗ” гэх/ - гэмтэлтэй нь “ТҮ-1”-ээр гэмтэлтэй вагоныг галт тэрэгнээс салгахгүйгээр хийх салгалтгүй засвар;

Төлөвлөгөөт бус урсгал засвар /цаашид “УЗ-1” гэх/ - вагоны гэмтэл нь салгалтгүй засвар “УЗ”-аар засварлах боломжгүй нь “ТҮ-1” үзлэгээр тогтоогдсон, засварын ажлыг тусгай тоноглолтой зам дээр гүйцэтгэх шаардлагатай салгалттай урсгал засвар;

Төлөвлөгөөт урсгал засвар /цаашид “УЗ-2” гэх/ - зорчигчийн вагоны төлөвлөгөөт засвар хооронд хийгдэх техникийн нэгдсэн байцаалт байна.

Дунд засвар /цаашид “ДЗ гэх) - вагоны ажлын чадвар, хэвийн байдал, дотоод нөөцийг хэсэгчилэн сэргээхийн тулд бүрдүүлэгч хэсгүүдийг хязгаарлагдмал нэр төрлөөр нь солих замаар депод хийгдэх засвар;

Их засвар /цаашид “ИЗ” гэх/ - вагоны ажлын чадвар, хэвийн байдал, дотоод нөөцийг бүрэн сэргээхийн тулд түүний бүрдүүлэгч үндсэн хэсгүүдийг бүрэн солих замаар хийгдэх засвар;

Нэгдүгээр хэмжээний их засвар /цаашид “ИЗ-1” гэх/ - элэгдсэн болон гэмтсэн эд анги, зангилаануудын гэмтлийг сэргээн засварлах эсвэл солих замаар вагоны техникийн бүрэн байдлыг ханган, ашиглалтын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор ачаа ба зорчигчийн вагонд хийгдэх их засвар;

Хоёрдугаар хэмжээний их засвар /цаашид “ИЗ-2” гэх/ - зорчигчийн вагонд дотоод хананаас нь тэвшний дотор гадарга хүртэл хэсэгчлэн задалж, тухайн хэсгийн дулаан тусгаарлагч ба цахилгаан дамжуулагчийг сольж, вагоны бусад элэгдсэн болон гэмтсэн эд анги, зангилаануудын гэмтлийг сэргээн засварлах эсвэл солих замаар вагоны техникийн бүрэн байдлыг ханган, ашиглалтын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хийгдэх их засвар;

Ачааны вагонд хийгдэх хоёрдугаар хэмжээний их засвар нь нэгдүгээр хэмжээний их засвартай адил байна;

Сэргээх их засвар /цаашид “СИЗ” гэх/ - зорчигчийн вагоны үйлдвэрээс тогтоосон эсвэл нормт эдэлгээний хугацаа дууссан үед ашиглалтын үлдэгдэл нөөцийг бүрэн ашиглах зорилгоор даацын элементүүдэд техникийн сорилт, оношилгоо хийж вагоны үндсэн болон бусад хэсгийг хүчжүүлэн сэргээн засварлах, шинээр солих замаар хийх төлөвлөгөөт их засвар. Түүнийг оношлон, тогтоосон хугацаанд ашиглана;

Төмөр замын мэргэжлийн байгууллага - төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг үйлчилгээ, оношилгоо, засвар хийх үйлдвэрлэлийн баазтай иргэн, аж ахуйн нэгж;

Вагон үйлдвэрлэл - үйл ажиллагааны тусгай эрх авсан үйлдвэр, үйлдвэрлэлийн бүх дамжлага, технологит үйл ажиллагааг гүйцэтгэх баримт бичгийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж хүлээн зөвшөөрөгдсөн, чиглэлийн мэргэшсэн мэргэжилтэнтэй, бүтээгдэхүүн нь экологи, эрүүл ахуй, эрэлт хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан байгууллага.

4. Вагоны ашиглалтанд нөлөөлөх хүчин зүйлс

Төмөр замын тээвэрт ашиглагдаж байгаа ачаа болон зорчигчийн вагоны техникийн байдалд дараах хүчин зүйлс нөлөөлөх тул вагоны төсөл, судалгаа, техник үйлчилгээ, засварын баримт бичиг боловсруулах, технологийн дагуу засвар, үйлчилгээ хийхдээ үүнийг тооцож байна.

4.1. Гадаад хүчин зүйлс:

- 4.1.1. Цаг уурын төлөв, байгалийн хүчин зүйл;
- 4.1.2. Ачилт буулгалтын ажлын үеийн технологийн зөрчил, вагонд үйлчлэх хүч, ачаалалтын/үйлчлэх хүчний нөлөөлөл;
- 4.1.3. Даац хэтрэлт;
- 4.1.4. Төмөр замын царигийн өөрчлөлт, тахир тойруу, зам төмрүүдийн түвшингийн зөрөө;
- 4.1.5. Ачих, буулгах техник, тоног төхөөрөмжийн хийц бүтэц, найдвартай ажиллагаа;
- 4.1.6. Ашиглалтын үеийн үйл ажиллагаа технологи;

4.2. Дотоод хүчин зүйлс:

- 4.2.1. Вагоны хийцийн үйлдвэрлэлийн технологийн алдаа;
- 4.2.2. Вагоны хийцийн материалын дотоод бүтэц, механик болон физик-химийн шинж чанарын алдагдалт, материалын чанар;
- 4.2.3. Вагоны засварын чанар;

5. Ерөнхий шаардлага

- 5.1. Вагоныг ашиглах нийт хугацааны туршид, аяллын явцад түүний аюулгүй, бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагаа хангагдахаар, тодорхой үечлэлээр дараах төрлийн техникийн үзлэг, үйлчилгээ засвар хийгдсэн байна:
 - урсгал засвар;
 - дунд засвар;
 - их засвар;
 - сэргээх их засвар;
- 5.2. Вагоныг дунд засварт оруулахдаа үечилсэн хугацаа, гүйлт гэсэн үндсэн хоёр төрлийн нормоор тооцож техникийн үйлчилгээ, засварт оруулна. Вагон эзэмшигч өөрийн вагонуудад хийгдэх техникийн үйлчилгээ, засварыг дээрх нормын аль нэгийг сонгож хэрэглэнэ.
- 5.3. Вагоныг их засварт оруулахдаа хугацааны үечлэлийг баримтална.
- 5.4. Гүйлтийн нормыг баримтлан вагоныг дунд засварт оруулах бол бодит гүйлт нь шалгуур хэмжээнд хүрээгүй боловч засварын үечилсэн хугацаа дууссан бол вагоныг дунд засварт оруулна.
- 5.5. Вагон эзэмшигч нь вагоноо 5.2; 5.3; 5.4-т заасан төрлөөр түүний техникийн байдал, үндсэн нормчлогдсон засварт цаг тухайд нь оруулж, засварласан байна.
- 5.6. Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засварыг батлагдсан стандарт, дүрэм, журам, технологи, нормоор; баталгаажуулагдсан техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслээр хийж, засварын чанарт техникийн

- оношилгооны шинжилгээ, үнэлгээ, дүгнэлтээр тэнцсэн эсэхийг тодорхойлж, баталгаа гарсан тохиолдолд ашиглалтанд хүлээлгэж өгнө.
- 5.7. Вагон эзэмшигч нь эзэмшилдээ байгаа вагоны техникийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцна.
 - 5.8. Вагон болон түүний эд ангид (явах анги, арал, ниших татах байгууламж, автомат тоормос г.м) техникийн оношилгоо, засвар хийсэн эрх бүхий засварын газар нь засварын чанарыг дараагийн төлөвлөгөөт засвар хүртэл хариуцна.
 - 5.9. Ашиглалтын үед вагоны техникийн найдвартай байдлыг түүнд техникийн үзлэг үйлчилгээ хийсэн байгууллага хөдөлгөөний аюулгүй ажиллагааны баталгаат хэсэглэлийн хэмжээнд хангах үүрэгтэй.
 - 5.10. Ачааны вагоны ашиглалтын хугацааг тогтоохдоо үйлдвэрлэгчээс тогтоосон норм хэмжээг баримтлах бөгөөд вагоны ашиглалтын хугацаа нь тодорхой бус тохиолдолд энэхүү стандартын А хавсралтыг, засварын үечлэлийн В хавсралтыг үндэслэн тогтооно.
 - 5.11. Вагоныг ачилтанд бэлтгэсэн байгууллага нь ачаа хүрэх өртөө хүртэл тухайн вагоны техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын хэвийн ажиллагааг хариуцна.

6. Вагоны ашиглалтад тавих шаардлага

- 6.1. Төмөр замын тээвэрт ашиглагдах вагон нь үйлдвэрлэгч болон захиалагч нар гэрээний дагуу зөвшилцсөн техникийн үзүүлэлт, нөхцөл, ажлын зураг болон Монгол Улсын үндэсний стандарт, байгаль, цаг уурын нөхцөл, засвар, ашиглалтын шаардлага зэргийг хангахаар үйлдвэрлэгдсэн байна.
- 6.2. Вагон, түүний зангилаа эд ангид хийгдэх техникийн үзлэг, үйлчилгээ, засвар, оношилгоо, хяналт шалгалтын техник, тоног төхөөрөмж, технологи нь эрүүл ахуй, ариун цэвэр, эргономик, экологийн шаардлага хангасан, баталгаажуулагдсан байх ба стандарт, дүрэм, журам, заавар, норм, технологийн горимын дагуу мэргэшсэн ажилтан гүйцэтгэж, засварын ажлыг батлагдсан маягт, баримт бичгүүдэд бүртгэлжүүлэн баримтжуулсан байна.
- 6.3. Вагоны засварын дүрмийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулах ба түүнийг вагон эзэмшигч, вагоны засвар үйлчилгээ хийдэг бүх байгууллага мөрдөнө.
- 6.4. Вагоны техникийн үйлчилгээ, засварын норм, тогтоосон норм хэмжээг вагоны ашиглалтын нөхцөл, орших газар зүйн байршлаас үл хамааран мөрдөж ажиллана.
- 6.5. Вагоны засвар хоорондын хугацаа, гүйлтийн шалгуур гүйцсэн тухай бүр төлөвлөгөөт засварт оруулж, засвар нь чанартай хийгдэж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг дараагийн төлөвлөгөөт засвар хүртэл бүрэн хангахаар баталгаажуулагдсан тохиолдолд ашиглалтанд оруулна.
- 6.6. Суурь бүтэц эзэмшигч, вагон эзэмшигч нар вагоны бодит гүйлтийг тооцох нэгдсэн автомат систем нэвтрүүлж, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан тохиолдолд тухайн вагон эзэмшигч вагоны засвар үйлчилгээний гүйлтийн системийг мөрдлөг болгож болно. Вагоны гүйлтийг нэгдсэн журмаар тооцох боломжгүй бол засвар хоорондын үечлэлийг гүйлтээр тооцохгүй.
- 6.7. Вагоны бодит гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр тогтоох техникийн

үйлчилгээ, засварын гүйлтийн системийг вагоныг шинээр үйлдвэрээс гарсны дараа эсвэл төлөвлөгөөт (их болон дунд) засварт орсны дараа төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр, улсын хэмжээд нэгдсэн бүртгэлд хамруулж, мөрдөж ажиллана.

- 6.8. Ашиглалтад байгаа вагоны засварлах үечилсэн хугацаа болон гүйлтийн нормын аль нэг норм нь гүйцсэн тохиолдолд өөрийн гол дээрх ачааны нэгэн адил бичиг баримтаар засварт явахаас бусад тохиолдолд галт тэргэнд холбож болохгүй.
- 6.9. Зорчигчийн вагоныг гүйлтийн системээр засвар, үйлчилгээнд оруулах бол төлөвлөгөөт урсгал засвар (УЗ-2)-ыг D хавсралтын D1 хүснэгтэд заасан хугацааны нормоор гүйцэтгэнэ.
- 6.10. Вагоны техникийн байдал, цаг уурын хүнд нөхцөл, осолд орсон шалтгаан зэргийг харгалзан үзэж засварын хугацаа ба гүйлтийн нормоос өмнө уг вагоныг засварлаж болно.
- 6.11. Вагон эзэмшигч нь вагоныг батлагдсан стандарт, дүрэм, журам, заавар, норм, технологийн горимын шаардлагад нийцүүлэн, техникийн үзлэг, үйлчилгээ, засварыг тогтоосон нормын дагуу хийлгүүлж, түүний техникийн бүрэн бүтэн байдал болон төмөр замын тээврийн аюулгүй байдлыг бүрэн хариуцан ашиглана.
- 6.12. Вагоны техникийн паспортанд түүний хийц, үйлдвэрлэлийн техникийн үндсэн үзүүлэлтүүд, ашиглаж эхэлсэн цагаас хойшхи техникийн үйлчилгээ, засварын төрөл (засварын хугацаа, гүйлтийн талаар), техникийн үйлчилгээ, засварын чанарын үнэлгээ, баталгааг тэмдэглэсэн байх бөгөөд шаардлагатай нэмэлт материалыг хавсаргана.
- 6.13. Вагон эзэмшигч нь вагоны ашиглалт, техникийн үйлчилгээ, засвар, ашиглалтаас хасагдсан, ашиглалтад шинээр оруулсан вагоны талаар мэдээллийн нэгдсэн баазтай байх бөгөөд тайланг жил бүр төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж хүргүүлнэ.
- 6.14. Вагонд сэргээх их засварыг гүйцэтгэх вагон засварын газар нь энэ төрлийн засвар хийх эрхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан байна.
- 6.15. Ашиглалтын нормт хугацаа дууссан вагоныг цаашид тээвэрлэлтэд дахин ашиглахдаа эрхийг техникийн сорилт, оношилгоо хийх итгэмжлэл, батламжтай байгууллагаар гаргуулсан техникийн тодорхойлолт, дахин ашиглах нөөцийн баталгаажуулалт, засвар хийсэн байгууллагын баталгааг үндэслэн төмөр замын асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллага нэг удаа олгож болно.
- 6.16. Сэргээх их засварын дараа вагоныг дахин ашиглах хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаа эсвэл ашиглалтын нормт хугацааны 30%-аас хэтрэхгүй байх ба төмөр замын тээврийн аюулгүй байдал, техникийн нөхцөл шаардлагыг бүрэн хангасан гэрчилгээг эрх бүхий байгууллагаас авсан байна.
- 6.17. Вагоны техникийн засварын газар нь сэргээх их засварыг хийхдээ дээрх баталгаажуулалт, дүгнэлтийг үндэслэн засварыг гүйцэтгэнэ.
- 6.18. Вагоны сэргээх их засварын үед вагоны динамик ачаалалд ордог тэвш, арал зэрэг зангилаа хэсгийн эд ангийг хүч нэмэгдүүлэн сайжруулна. Мөн солигддог эд ангийг шинээр угсарна.
- 6.19. Тусгай зориулалтын зорчигчийн вагонд сэргээх их засварыг хийхгүй.
- 6.20. Ачааны болон зорчигчийн вагоны зориулалтыг өөрчлөх болон шинэчлэн тоноглох тохиолдолд сэргээгдэх их засвар хийх журмын дагуу гүйцэтгэж,

баталгаажуулсан байна.

- 6.21. Вагоны төлөвлөгөөт урсгал, дунд, их засварын норм дууссан тохиолдолд төмөр замын тээвэрт ашиглахгүй ба зайлшгүй нөхцөлд /тухайлбал төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд вагоны хүрэлцээ дутах, засварын газрын ачаалал хэтэрснээс вагоныг хугацаанд нь засварт хүлээн авах боломжгүй болсон/ вагон эзэмшигчийн хүсэлтээр, суурь бүтцийн засварын депогийн мэргэжлийн комиссын техникийн дүгнэлтийг үндэслэн, засварын хугацааг ачааны вагонд 1 удаа 6 сар хүртэл, зорчигчийн вагонд 1 удаа 1 сар хүртэл хугацаагаар сунган, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангуулан суурь бүтэц дээгүүр аялуулж болно.
- 6.22. Ачааны вагоныг эрүүлжүүлэх засвараар өвөл, зуны тээвэрлэлтэд нэгдсэн журмаар бэлтгэнэ. Зорчигчийн вагоны өвөл зуны тээвэрлэлтэд бэлтгэсний дараа тухайн суурь бүтэц эзэмшигчийн томилсон комисс тээвэрт хүлээж авна.
- 6.23. Төмөр замын суурь бүтэц эзэмшигч, вагон эзэмшигч нь ашиглалтын үед вагонд гарсан техникийн гэмтлийг төлөвлөгөөт бус урсгал засварт оруулж стандарт, дүрэм, журам, заавар, норм, технологийн горим зэргийн дагуу засварлаж, ашиглалтын нөхцөл хангагдсан баталгаажуулсан тохиолдолд галт тэргэнд холбож явуулна.
- 6.24. Вагоны бүх төрлийн засварт зориулсан эд ангийг үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаа, нормын дагуу ашиглаж, үечилсэн засварт оруулна.
- 6.25. Вагон түүний зангилаа эд ангид тавих тэмдэг, тэмдэглэгээ болон тогтоосон нормт техникийн үйлчилгээ, засварын бичиглэлийг MNS EN15380-1,2,3:2016 стандартын дагуу гүйцэтгэсэн байна.

7. Вагоны засвар ашиглах эд ангид тавигдах шаардлага

- 7.1. Бүх төрлийн засварын үед үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалтын хугацаа хэтэрсэн цутгамал эд ангийг вагонд угсарч болохгүй.
- 7.2. Засварын үед вагонд шинэ болон сэргээн засварласан эд ангийг тавьж болох ба ямар ч тохиолдолд эд ангийг туршилт, сорилтод оруулж баталгаажуулсан байна.
- 7.3. Сэргээх их засварын үед вагоны солигддог эд ангийг шинээр тавина.

8. Вагоны техникийн үйлчилгээ, засварын үечилсэн норм

- 8.1. Вагон түүний эд ангийн засварын ажлын хэмжээ ба сэргээгдэх чадварын түвшнээс хамааруулан ачааны вагонд техникийн үзлэг, үйлчилгээ, урсгал, дунд, их засварыг гүйцэтгэнэ. (E хавсралтын E1 схем)
- 8.2. Вагон түүний эд ангийн нөөцийг сэргээх түвшнээс хамааруулан зорчигчийн вагонд техникийн үзлэг, үйлчилгээ, урсгал засвар, дунд засвар, нэгдүгээр болон хоёрдугаар хэмжээний их засвар, сэргээх их засварыг гүйцэтгэнэ. (E хавсралтын E2 схем)
- 8.3. Зорчигчийн вагоны төлөвлөгөөт урсгал засвар, дунд, их засварын хугацааны үечлэл ба гүйлтийн нормыг C, D хавсралтын хүснэгтүүдэд үзүүлсний дагуу гүйцэтгэнэ.
- 8.4. Зорчигчийн вагоны нарийн царигийн явах ангид хийгдэх төлөвлөгөөт засварыг тухайн вагон бүрт хийгдэх нормт засвартай ижил нормоор засварлана.

- 8.5. Ачааны вагоны төлөвлөгөөт засвар хоорондын хугацаа болон гүйлтийг А,В хавсралтыг үндэслэн тогтоож, засварыг гүйцэтгэнэ.
- 8.6. Дунд засварын үечлэлийн нормыг дараах системээр тогтооно:

- Дунд засварын гүйлтийн системийн үечлэлийг вагоны бодит гүйцэтгэсэн ажлын хэмжээ ба ашиглалтын хугацааны үргэлжлэлийг ашиглан тогтооно;
- Дунд засварын нэгж системийн үечлэлийг вагоны үйлдвэрлэгдсэн хугацаанаас эхлэн дараагийн төлөвлөгөөт засварт орох хүртэл, эсвэл төлөвлөгөөт засвараас дараагийн төлөвлөгөөт засвар хүртэлх ашиглалтын хугацааны үргэлжлэлийг ашиглан тогтооно;

9. Ачаа ба зорчигчийн вагоны техникийн засварын төрөл, ангилал, засварын хугацаа, гүйлтийн үечлэл.

Ачаа ба зорчигчийн вагоны техникийн засварын төрөл, ангилал, засварын хугацаа, гүйлтийн үечлэл нь дараах хүснэгтэд заасны дагуу байна.

Хүснэгт 1. Ачаа ба зорчигчийн вагоны засварын төрөл, ангилал

д/д	Шинж чанар	Засварын төрлүүд	
		Зорчигчийн вагон	Ачааны вагон
1	Вагоны ажлын чадварыг сэргээх зэрэглэл	1.1. Сэргээх их засвар	1.1. Сэргээх их засвар
		1.2. Нэгдүгээр хэмжээний их засвар	1.2. Их засвар
		1.3. Хоёрдугаар хэмжээний засвар	1.3. Дунд засвар
		1.4. Дунд засвар	1.4. Салгалттай урсгал засвар
		1.5. Салгалттай урсгал засвар	1.5. Салгалтгүй урсгал засвар
		1.6. Салгалтгүй урсгал засвар	1.6. Эрүүлжүүлэх засвар
		1.7. Комиссийн үзлэг	
3	Хугацаагаар төлөвлөх	2.1. Төлөвлөгөөт	
		2.2. Төлөвлөгөөт бус	
4	Сэргээх засварлах ажлын хэмжээг төлөвлөх	3.1. Ажлын хэмжээ тогтоогоогүй	
		3.2. Ажлын хэмжээ тогтоосон	
5	Вагоны засварт орох үеийн техникийн байдал	4.1. Ослын дараах	
		4.2. Урьдчилан сэргийлэх	
6	Засварын зохион байгуулалтын хэлбэрээр	5.1. Суурин арга	
		5.2. Дамжлагаарга	
	Засварыг гүйцэтгэгч	6.1. Эзэмшигч байгууллага	
		6.2. Гэрээт засварын газар	
		6.3. Үйлдвэрлэгч	

ТӨГСӨВ.

АХавсралт
(Норматив)

**А.1 Хүснэгт: АЧААНЫ ВАГОНЫ АШИГЛАЛТЫН НОРМТ ХУГАЦАА,
ИХ ЗАСВАР ХООРОНДЫН ХУГАЦААНЫ ҮЕЧЛЭЛ**

Д/Д	Ачааны вагоны төрөл	Ашиглалтын нормт хугацаа (жил)	Үйлдвэрлэсэнээс хойш их засвар хүртэл хугацаа (жил)
1.ОХУ-д үйлдвэрлэгдсэн вагон			
1.1.Түгээмэл хэрэглээний вагон			
1.1.1	Битүү	32	13
1.1.2	Тавцант	32	13
1.1.3	Хагас	30	13
1.1.4	Тунгалаг нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх цистерн	32	13
1.1.5	Түүхий нефть тээвэрлэх цистерн	32	13
1.1.6	Шахсан шингэрүүлсэн хий тээвэрлэх цистерн	24	11
1.1.7	Ундны ус тээвэрлэх цистерн	32	13
1.1.8	Думпкар	23	9
1.1.9	Хоппер	28	13
1.1.10	Хоппер тугнуур	25	11
1.2.Тусгай хэрэгцээний вагон			
1.2.1	Сэргээн босгох галт тэрэгний вагон	32	15

1.2.2	Галын галт тэрэгний вагон	32	15
1.2.3	Тусгай зориулалтын нэмэлт тоноглол бүхий ачааны вагон	25	12
2.БНХАУ-д үйлдвэрлэсэн			
2.1.Түгээмэл хэрэглээний Е маягийн вагон			
2.1.1	Битүү	25	12
2.1.2	Тавцант	25	12
2.1.3	Хагас	25	12
2.1.4	Хүдэр тээвэрлэх хагас	25	12
2.1.5	Хоппер	30	12

В Хавсралт
(Норматив)

В.1 Хүснэгт: АЧААНЫ ВАГОНЫ ДУНД ЗАСВАР ХООРОНДЫН ХУГАЦАА, БОДИТ ГҮЙЛТ

ДД	Вагоны төрөл	Засвар хоорондын үечлэл (хугацаагаар болон бодит гүйлтээр)							
		Үйлдвэрлэсний дараа				Их засварын дараа			
		Эхний дунд засвар		Бусад дунд засвар		Эхний дунд засвар		Бусад дунд засвар	
		жил	мян.км	жил	мян.км	жил	мян.км	жил	мян.км
1	2	3	4	5	6	7	8	9	10
1. ОХУ-д үйлдвэрлэгдсэн вагон									
1.1. Түгээмэл хэрэгцээний вагон									
1.1.1	Битүү	3	210	2	110	3	160	1	75
1.1.2	Тавцант	3	210	2	110	3	160	1	75
1.1.3	Хагас	3	210	2	110	3	160	1	75
1.1.4	Тунгалга нефтийн бүтээгдэхүүнд зориулсан цистерн	3	210	2	110	3	160	1	75
1.1.5	Түүхий нефтид зориулсан цистерн	3	210	2	110	3	160	1	75
1.1.6	Шахсан, шингэрүүлсэн хийд зориулсан цистерн	3	210	2	110	3	160	1	75
1.1.7	Ундны усанд зориулсан цистерн	3	210	2	110	3	160	1	75
1.1.8	Думпкар	3	210	2	110	3	160	1	75
1.1.9	Хоппер	3	210	2	110	3	160	1	75
1.1.10	Хоппер тугнуур	3	210	2	110	3	160	1	75
1.2. Тусгай хэрэгцээний вагон									
1.2.1	Сэргээн босгох галт тэрэгний вагон	3	210	2	110	3	160	1	75
1.2.2	Галын галт тэрэгний вагон	3	210	2	110	3	160	1	75

1.2.3	Тусгай зориулалтын нэмэгдэл тоноглол бүхий вагоны	2	180	1	160	2	120	1	60
2. БНХАУ-д үйлдвэрлэсэн вагон									
2.1	Битүү	4	500	2	160	3	210	1	75
2.2	Тавцант	4	500	2	160	3	210	1	75
2.3	Хагас	4	500	2	160	3	210	1	75
2.4	Хүдэрт зориулсан хагас вагон	4	500	2	160	3	210	1	75
2.5	Хоппер	4	500	2	160	3	210	1	75

ТАЙЛБАР:

- Өөрчлөн тоногосон болон өөр зориулалтаар ашиглаж байгаа вагоны засвар хоорондын хугацааг тухайн вагоны анхны үндсэн төрлөөр нь тогтооно.
- Шинэ сайжруулсан төслөөр үйлдвэрлэсэн ачааны вагоны үйлдвэрлэгчээс тогтоосон нормоор засвар хоорондын хугацааг тогооно.

С Хавсралт
(Норматив)

**С.1 Хүснэгт: ЗОРЧИГЧИЙН ВАГОНЫ АШИГЛАЛТЫН НОРМТ ХУГАЦАА,
ИХ ЗАСВАР ХООРОНДЫН ХУГАЦААНЫ ҮЕЧЛЭЛ**

ДД	Вагоны төрөл	Ашиглалтын хугацаа (жилээр)	Үечлэлийн норм (жилээр)		
			Үйлдвэрлэснээс 2-р их засвар хүртэл		2-р их засвараас ашиглалтын тогтоосон хугацаа дуустал
			ИЗ-1	ИЗ-2	ИЗ-1
	2	3	4	5	6
1	Тасалгаат, унтлагын болон нийтийн вагон	28	6	18	5
2	Зоогийн вагон	28	5	15	5
3	Тэвш, арал, үрэлтийн эд анги, зангилаа хэсэг нь нэмэгдэл нөөцтэй болох нь техникийн нөхцөл, заавраар тогтоогдсон, хайрцгийн холхивчтой гүүшинтэй вагон	30	6	18	6
4	Тээшийн вагон	28	6	18	6
5	Тусгай галт тэрэгний вагон	28	6	18	6
6	Замын хэмжилт, оношлогооны вагон	25	10	20	-
7	Галын болон сэргээн босгох галт тэрэгний вагон	28	15	20	8
8	Цахилгаан станц бүхий вагон (дизель вагон)	25	5	15	5
9	Бусад техникийн болон албаны хэрэгцээний вагон	28	6	18	8


ДХавсралт
(Норматив)

**D.1 Хүснэгт: ЗОРЧИГЧИЙН ВАГОНЫ УРСГАЛ, ДУНД ЗАСВАРЫН
ХООРОНДЫН ХУГАЦАА БОЛОН ГҮЙЛТИЙН НОРМ**

ДД	Вагоны төрөл	Засвар хоорондын үечлэл (хугацаагаар болон бодит гүйлтээр)							
		Өнхрөх холхивчтой хос дугуйтай зорчигчийн вагон				Үрэлтийн эд анги, зангилаа хэсэг нь нэмэгдэл нөөцтэй болох нь техникийн нөхцөл, заавраар тогтоогдсон, хайрцагийн холхивчтой гүүшинтэй зорчигчийн вагон			
		урсгал засвар-2		Дунд засвар		Урсгал засвар-2		Дунд засвар	
		жил	мян.км	жил	мян.км	жил	мян.км	жил	мян.км
1. Нийтийн тээвэрт зориулагдсан зорчигчийн вагон									
1	2	3	4	5	6	7	8	9	10
1.1	Тасалгаат, унтлагын, нийтийн	6	125	12	250	12	250	36	500
1.2	Зоогийн	6	125	12	250	12	250	24	500
1.3	Тээшийн	6	125	12	250	12	250	36	500
1.4	Сэргээгдэх их засвар хийгдсэн вагон	6	-	12	-	-	-	-	-
2. Тусгай зориулалтын зорчигчийн вагонууд									
2.1	Тусгай галт тэрэгний	12	-	24	-	12	-	24	-
2.2	Зам хэмжигч, оношлогооны	12	-	24	-	12	-	24	-
2.3	Галын вагон сэргээн босгох галт тэрэгний	12	-	36	-	12	-	36	-
2.4	Цахилгаан станц бүхий (дизель вагон)	6	-	12	-	6	-	12	-
2.5	Бусад техникийн зориулалттай албаны хэрэгцээний	12	-	36	-	12	-	36	-

Е Хавсралт

Е.1 Хүснэгт: АЧААНЫ ВАГОНЫ ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАРЫН ТӨРӨЛ АНГИЛАЛ



Е.2 Хүснэгт: ЗОРЧИГЧИЙН ВАГОНЫ ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАРЫН ТӨРӨЛ АНГИЛАЛ

